

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүмбэр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2025/001/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Говьсүмбэр аймаг</p> <p>2025 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179, Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Аудитор: С.Батцэцэг Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу..

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

2025.03.25 № 56
танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
СҮМБЭР СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
Э.ДАВААДОРЖ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн нэгтгэсэн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан 5 байгууллагын нийт зөрчил 1,575.2 сая төгрөг бөгөөд гол зөрчил болох "Энхтүсдэм" өрхийн эрүүл мэндийн төв нь санхүүгийн тайландаа аудит хийлгээгүй, нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийгдээгүй тайланг нэгтгэсэн, санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн баталгаажаагүй 1,107.9 сая, төсвийн гүйцэтгэл болон барьцааны дансны үлдэгдэлтэй холбоотой 192.4 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9, 8.9.3 15 дугаар зүйлийн 15.4, 15.4.2 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг,

422502242

нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Гол үндэслэл нь MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”:6 төрийн аудитын зарчим, 6.4.3.1.3 Санал дүгнэлт, 6.4.3.1.3.1 Хязгаарлалттай - Аудитор шалгах зүйлд багтсан материаллаг боловч өргөн тархаагүй тодорхой зүйлийн талаар хангалттай ба зохистой нотлох зүйл олж авах боломжгүй эсвэл зөвшөөрөхгүй байгаа нөхцөлтэй санал нийлэхгүй үед, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/66 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан АДБОУС 200 “Санхүүгийн аудитын зарчим” стандартын 64-т Аудитор нь дараах гурван төрлийн өөрчлөлттэй санал дүгнэлтийг гаргаж болно: хязгаарлалттай санал дүгнэлт - аудитор буруу илэрхийлэл дангаараа эсхүл нийлээд материаллаг боловч өргөн тархаагүй, эсхүл байж болзошгүй буруу илэрхийллийн талаар хангалттай, зохистой аудитын нотолгоо олж авах боломжгүй гэж дүгнэсэн үед, 78-т Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж буй аудитор нь санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлж бэлтгэсэн эсэхэд санал дүгнэлт өгөхийн тулд түүний бүрэлдэхүүн тайлангуудын санхүүгийн мэдээлэл, нэгтгэлийн үйл явцын найдвартай байдлын талаар хангалттай, зохистой аудитын нотолгоог бүрдүүлэх шаардлагатай гэж заасан.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан боловч аудитаар баталгаажгаагүй санхүүгийн тайланг толилуулсан болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

/мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		5,360,812.2	5,235,236.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	3,216,500.3	3,099,807.5
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	775,289.4	670,094.5
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	1,407.6	322.2
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	1,239,122.8	1,448,821.9
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	47,314.9	16,190.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	81,177.2	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,112,036.8	1,716,272.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,112,036.8	1,716,272.5
39200	Биет хөрөнгө		1,032,239.3	1,561,769.8
39300	Биет бус хөрөнгө	13	79,797.5	154,502.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		6,472,849.0	6,951,508.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		87,476.8	214,848.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	87,476.8	214,848.5
41300	Өглөг	17а, 17б	81,813.3	214,848.5
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	5,663.5	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		6,385,372.1	6,736,660.2
51	Засгийн газрын хувь оролцоо		6,385,372.1	6,736,660.2
51100	Засгийн газрын оруулсан капитал		966,728.5	1,038,822.5
51200	Хуримтлагдсан үр дүн		5,215,822.5	5,540,794.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		202,821.2	157,043.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		6,472,849.0	6,951,508.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		13,071,492.1	14,252,614.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО		6,796,946.2	9,860,128.2
110	Орлогын албан татвар		5,774,767.5	8,728,477.9
1100	Хувь хүний орлогын албан татвар		6,029,138.3	9,049,920.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-254,370.8	-321,442.8
113	Хөрөнгийн албан татвар		506,529.3	484,750.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж		515,649.4	646,900.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	374,757.0	1,088,764.6
120	Нийтлэг татварын бус орлого		374,757.0	1,088,764.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		5,899,788.9	3,303,721.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	11,013,811.6	13,911,538.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ		11,013,811.6	13,911,538.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,027,777.9	8,259,529.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,424,971.0	2,134,389.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		176,104.4	250,990.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		113,216.2	1,437,567.7
2104	Хангамж, бараа материалын зардал		840,191.0	2,730,297.9
2105	Нормативт зардал		156,003.5	170,338.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		25,899.8	116,078.9
2107	Томилолт, зочны зардал		19,575.0	37,236.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,011,874.9	866,643.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		259,942.0	515,987.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,986,033.7	5,652,008.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		2,057,680.5	341,075.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		248,266.5	62,547.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		1,809,414.1	278,527.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруул а	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		12,935,266.2	13,326,895.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО		6,796,946.2	9,860,128.2
110	Орлогын албан татвар		5,774,767.2	8,728,477.2
1100	Хувь хүний орлогын албан татвар		6,029,138.2	9,049,920.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-254,370.2	-321,442.2
113	Хөрөнгийн албан татвар		506,529.2	484,750.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж		515,649.2	646,900.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		195,482.2	293,374.2
1181	Газрын төлбөр		277,156.2	242,457.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		43,010.2	111,068.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		269,742.2	163,744.2
120	Нийтлэг татварын бус орлого		269,742.2	163,744.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		5,868,577.2	3,303,022.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		10,110,295.2	11,093,217.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ		10,110,295.2	11,093,217.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,102,021.2	5,431,450.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,446,539.2	2,143,615.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлө шимтгэл		182,473.2	254,947.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		116,405.2	1,441,460.2
2104	Хангамж, бараа материалын зардал		69,331.2	98,359.2
2105	Нормативт зардал		80,191.2	70,984.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		54,389.2	141,215.2
2107	Томилолт, зочны зардал		19,575.2	37,236.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,031,166.2	889,557.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		101,950.2	354,073.2
211	ХҮҮ		0.2	0.2
212	ТАТААС		0.2	0.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		6,008,273.2	5,661,767.2

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		2,824,971.0	2,233,677.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		830,441.0	2,349,240.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		830,441.0	2,349,240.0
2200	Дотоод эх үүсвэрээр		830,441.0	2,349,240.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-830,441.0	-2,349,240.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-560.0	-1,130.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		560.0	1,130.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		1,993,969.0	-116,692.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,222,530.0	3,216,500.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,216,500.0	3,099,807.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,590,742.8	0.0	4,590,742.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	309,069.2	0.0	309,069.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,899,811.9	0.0	4,899,811.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-323,853.9	0.0	-323,853.9
9	Тайлант үеийн үр дүн	1,809,414.1	0.0	1,809,414.1
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,385,372.1	0.0	6,385,372.1
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,385,372.1	0.0	6,385,372.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	46,443.8	0.0	46,443.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,431,815.9	0.0	6,431,815.9
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-45,777.6	0.0	-45,777.6
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	72,094.0	0.0	72,094.0
19	Тайлант үеийн үр дүн	278,527.8	0.0	278,527.8
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,736,660.2	0.0	6,736,660.2

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,525,008.7	7,291,016.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,324,537.0	4,891,540.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,779,766.0	4,471,831.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,532,876.0	1,439,785.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	193,685.0	162,893.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,565,419.0	1,430,597.99
2104	Хангамж, бараа материалын зардал	61,175.0	59,792.79
2105	Нормативт зардал	250.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	166,416.0	165,271.18
2107	Томилолт, зочны зардал	35,424.0	33,562.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	878,765.0	876,240.81
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	345,756.0	303,687.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	544,771.0	419,709.34
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	527,790.0	402,954.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,981.0	16,755.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,811,847.7	2,398,346.41
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	388,624.0	1,130.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,525,008.7	7,291,016.76
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,421,640.0	2,345,582.60
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,967,626.1	4,620,563.75
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,135,742.6	114,918.13
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,048,448.74
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	838,496.46

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**/мянган төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	49,224.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	49,224.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,740.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,290.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	950.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,504.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,504.8
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	49,224.8
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,224.8

Гурав. Аудитын илрүүлэлт:

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар залруулга хийгдээгүй байна.

Аудитаар нийт 692.2 сая төгрөгийн 5 зөрчил¹ илэрснээс, 8.5 сая төгрөгийн 1 зөрчилд 1 төлбөрийн акт, 683.7 сая төгрөгийн 4 зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн, 1 “Энхтусдэм” ӨЭМТ нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад “Өөрчлөлтгүй” дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүвэрт хамрагдаж, “Энхтусдэм” ӨЭМТ аудит хийлгэхээс татгалзаж аудитад шаардлагатай баримт материал ирүүлээгүй тул дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 407.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 132.4 сая төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж, 1.1 сая төгрөгийн 2 зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 273.7 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 4 зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүлсэн байна. /Хавсралт 1-ээс үзнэ үү/

Өмнөх онтой харьцуулахад харьяа байгууллагуудын нийт зөрчлийн дүн 36% буюу 154.7 сая төгрөгөөр буурсан байна. Төлбөрийн акт 73% буюу 3.0 сая, албан шаардлага 30% буюу 119.6 сая буурсан, зөвлөмж 33% буюу 1 зөвлөмжөөр тус тус өссөн байна.

Залруулагдаагүй нийт зөрчлийн 1,575.2 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

3.1 Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

3.1.1 Төлбөрийн акт

- ОНХС-гийн барьцаа дансанд барьцаа хөрөнгийн хугацаа дууссан, он удаан жил болсон, ажил дутуу хийгдсэний улмаас чөлөөлөх боломжгүй 2 ажлын үлдэгдэл 9.9 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж эргэлтэд оруулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, 15 дугаар зүйлийн 15.4.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1.2 Албан шаардлага

- 2024 оны төсвийн тодотголоор Сүмбэр сумын ЗДТГ, Сүмбэр сумын ИТХ-ын төсвийг гүйцэтгэлд үндэслээгүй, тооцоо судалгаагүй их хэмжээгээр нэмэгдүүлж батлуулсан байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 15 дугаар зүйлийн 15.4.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, 22 дугаар зүйлийн 22.1.5, 59 дүгээр зүйлийн 59.1.9, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны зөвлөмжийг биелүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэв. Төсвийн тодотголоор харьяа байгууллагуудын төсвийг бодитой, үр ашигтай байхаар хүлээгдэж буй гүйцэтгэл, тооцоо судалгаанд үндэслэж батлуулах

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нэгтгэсэн тайлантай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: "Энхтүсдэм" өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлангийн аудит хамрагдаагүй санхүүгийн тайланг нэгтгэсэн

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9, 8.9.3, 15 дугаар зүйлийн 15.4, 15.4.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийгдээгүй санхүүгийн тайланг нэгтгэхгүй байх

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг тогтоосон хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Тав.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		